



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/184

Улаанбаатар хот

Санхүүжилтийн тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 122 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн 2024 оны төсөвт батлагдсан “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” ХК-ийн дүрмийн сангийн хөрөнгөд зориулах 1,800,000,000 (нэг тэрбум найман зуун сая) төгрөгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Энхжин)-т зөвшөөрсүгэй.

2. Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан хөрөнгийг холбогдох байгууллагын удирдлагатай байгуулсан “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин”-д заасны дагуу санхүүжүүлж, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110200968